대한결핵협회
Korean National Tuberculosis Association

janssen

СҮРЬЕЭГҮЙ ДЭЛХИЙ

# Lung tree note

Mongolia

Stop TB Partnership KOREA

환자수첩-몽골.indd 1 2016. 11. 15. 오후 5:01

# Агуулга

## I хэсэг. Сүрьеэ өвчний тухай ерөнхий ойлголт

- Сүрьеэ өвчин гэж юу вэ? Сүрьеэ өвчин үүсгэгч нянгийн хэлбэр, шинж чанар юу вэ?
- Сүрьеэгийн халдвар хэрхэн тархдаг вэ?
- Сүрьеэ өвчний үед ямар илрэх шинж тэмдэгүүд илэрдэг вэ?
- Сүрьеэ өвчнийг хэрхэн оношлодог вэ?
- Сүрьеэ өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?

## II хэсэг. Сүрьеэ өвчний эмчилгээ

- Сүрьеэ өвчнийг хэрхэн эмчилдэг вэ?
- Сүрьеэтэй өвчтөнийг эмчлэх эмчилгээний үе шатуудын талаар хангалттай мэдээлэлтэй байна уу?
- Сүрьеэ өвчнийг анагаах ямар төрлийн эм, тарилга байдаг вэ?
- I түвшний эмчилгээний үед ямар гаж нөлөө илэрч болох вэ?
- Сүрьеэгээр өвчилсөн тохиолдолд анхаарах зүйлс юу вэ?
- Нуугдмал сүрьеэ өвчин гэж юу вэ? Хэрхэн эмчлэгддэг вэ?
- Сүрьеэгийн халдвартай өвчтөний гэр бүлд зориулсан “Нуугдмал сүрьеэг илрүүлэх шинжилгээ - төсөл” гэж юу вэ?

## III хэсэг. Эмэнд дасал сүрьеэ

- Эмэнд дасалтай сүрьеэ хэрхэн үүсдэг вэ?
- Эмэнд дасал сүрьеэгийн олон янз байдаг уу?
- Олон эмэнд дасал сүрьеэг хэрхэн эмчилдэг вэ?
- II түвшний эм, тарилгаас үүсч болох үндсэн гаж нөлөө юу вэ?
- Сүрьеэгийн эсрэг шинэ төрлийн эм, тарилга байгаа юу?
- Сүрьеэ өвчин эдгэрсний дараа дахин өвчлөх магадлалтай юу?

I хэсэг.

# Сүрьеэ өвчний тухай ерөнхий ойлголт

환자수첩-몽골.indd 3 2016. 11. 15. 오후 5:01

## “Сүрьеэ өвчин гэж юу вэ[1]?”

- Сүрьеэ нь сүрьеэгийн нян болох микобактери хэмээх нянгаар халдвар лан, үрэвслийн голомтын ихэнх буюу 85% нь хүний биеийн уушги бол он бусад эрхтэнд үүсгэгддэг өвчин юм.






## “Сүрьеэ өвчин үүсгэгч нянгийн хэлбэр, шинж чанар юу вэ[1]?”

- Сүрьеэ өвчин үүсгэгч микобактери нь савханцар хэлбэртэй, удаан үрж дэг халдварт нян юм. Уг өвчин хүн төрөлхтнийг өвчлүүлж бүй хамгийн эртний өвчнүүдийн нэг юм.



√ Сүрьеэ өвчин нь микобактери хэмээх нянгаар үүсгэгддэг.

√ Микобактери нь савханцар хэлбэртэй, удаан хугацааны турш амьдрах чадвартай, хуваагдан үрждэг нян юм.



환자수첩-몽골.indd 4 2016. 11. 15. 오후 5:01

## “Сүрьеэгийн халдвар хэрхэн тархдаг вэ[1]?”

• Сүрьеэгийн нян хүнээс хүнд амьсгалын замаар халдварладаг.

1. Сүрьеэ өвчтэй хүнийг ярих, ханиах, найтаахад эргэн тойронд нь их хэм жээний сүрьеэгийн нян тархаж бай даг.
2. Уг нян агаарт тархсан хэвээр үлддэг
3. Өвчтөнтэй ойр байсан хүн уг нянта й агааараар амьсгалсанаар халдвар авч, улмаар уг нян уушгинд нэвтэр ч өвчлүүлдэг.



환자수첩-몽골.indd 5 2016. 11. 15. 오후 5:01

## “Сүрьеэ өвчний үед ямар илрэх шинж тэмдэгүүд илэрдэг вэ[2]?”

- **Өвчний үед илрэх үндсэн шинж тэмдэгүүд**
  - Ханиах 2 ба түүнээс дээш долоо хоногоор ханиавал сүрьеэгийн шинжил гэж өгөх
  - Цусан ханиалга Цустай цэрээр ханиах
  - Амьсгал боогдох Бага зэрэг хөдлөхөд ч амьсгал боогдон багтрах
  - Толгой эргэх ядрах Амархан ядрах,бие сульдах
  - Халуурах хөлрөх Халуурах, шөнөөр хөлрөх








환자수첩-몽골.indd 6 2016. 11. 15. 오후 5:01

## “Сүрьеэ өвчнийг хэрхэн оношлодог вэ[2]?”

- Сүрьеэг оношлоход хамгийн оновчтой шинжилгээ бол цэрний түрхэцийн шинжилгээ юм. Мөн үтрээний түрхэцийн шинжилгээ болон бусад төрлийн эд эс, молекул биологийн шинжилгээнүүдээр оношлогддог.



## Түүнчлэн бусад төрлийн шинжилгээнүүд өгч болно.

- Рентген шинжилгээ

Цээжний рентген шинжилгээ сүрьеэг оношлоход ашигладаг.

- Туберкулины арьсан дээрх сорил

сүрьеэ өвчний нянг илрүүлэхэд ашиглагддаг.

- Эмэнд дасал сүрьеэг оношлох тест

Сүрьеэ өвчнийг эмэнд дасал болсон эсэхийг оношлох шинжилгээ нь өвчтөнд эмчилгээг тохируулахад тустай.

√ Сүрьеэг оношлоход хамгийн оновчтой шинжилгээ бол цэрний шинжилгээ юм.

√ Сүрьеэ өвчний эсрэг эмэнд дасал болсон эсэхийг оношлох шинжилгээ нь өвчтөнд тохирох эмчилгээг олоход хэрэглэгддэг.



환자수첩-몽골.indd 7 2016. 11. 15. 오후 5:01

## “Сүрьеэ өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?[1]?”

### Сүрьеэ өвчний эсрэг БЦЖ тарилга

- БЦЖ вакцин нь сүрьеэ өвчний эсрэг биеийн дархлааг сайжруулахад хэрэглэгддэг.
- Уг вакцин нь ихэвчлэн бага насны хүүхэд болон нярай хүүхдүүдийг сүрьеэ өвчний халдвар авахаас урьдчилан сэргийлдэг.
- Вакциныг нярай хүүхдүүдэд төрснөөс хойш 1 сарын дотор хийлгэх шаардлагатай.

### Биеийн дархлаа сайжруулалт

- Ядарч эцэх, сэтгэлээр унах, их хэмжээгээр биеийн жин хасагдсанаас биеийн дархлаа муудах нь сүрьеэ өвчний халдвар авах нөхцлийг бүрдүүлдэг.
- Эрүүл зөв хооллож, биеийн эсэргүүцлээ сайжруулах, дархлааг тэтгэх нь чухал.
- Архи тамхинаас татгалзах хэрэгтэй.






환자수첩-몽골.indd 8 2016. 11. 15. 오후 5:01

II хэсэг.

# Сүрьеэ өвчний эмчилгээ

## “Сүрьеэ өвчнийг хэрхэн эмчилдэг вэ[1]?”

Сүрьеэгийн нян зөвхөн сүрьеэгийн эсрэг эмч илгээгээр устгагддаг: Сүрьеэ өвчин 3-4 үе ша т бүхий эмчилгээг 6-аас дээш сарын хугацаан д тууштай хийсний үр дүнд эдгэрдэг.

Эмчийн зөвлөгөө зааваргүйгээр сүрьеэгийн эмчил гээг зогсоож болохгүй. Эмийг эмчийн зөвлөсөн за аврын дагуу, тогтмол цаг хугацаанд нь уух нь чуха л.

Сүрьеэ өвчний эмчилгээ эмч, эрүүл мэндийн ажилтны хяналтан дор үргэлжлэх ёстой. Эмч илгээний явц, ахиц болон эмийн гаж нөлөөг ш алгаж, 2-3 сар тутам цээжний рентгэн болон ц эрний шинжилгээг авдаг.

- √ Сүрьеэ өвчинд зөв эмчилгээ хийвэл эдгэрэх бүрэн боломжтой.
- √ Сүрьеэ өвчнийг олон төрлийн цогц эмийг удаан хугацааны турш хэрэглэсний үр дүнд эмчлэнэ.
- √ Сүрьеэ өвчнийг эмчилгээний зааврын дагуу удаан хугацаанд т асалдалгүй эмчлэх нь чухал.
- √ Өвчний эдгэрэлтийг цээжний рентгэн болон цэрний түрхэцийн шин жилгээгээр давтамжтайгаар шалгаж тодорхойлно.



환자수첩-몽골.indd 10 2016. 11. 15. 오후 5:01

# “Сүрьеэтэй өвчтөнийг эмчлэх эмчилгээний үе шатуудын талаар хангалттай мэдээлэлтэй байна уу[1]?”

## Зорилт:

- Сүрьеэгийн өвчтөнд тохирох цогц эмчилгээг хийх ба эмийн гаж нөл өө байгаа эсэхийг хянах
- Өвчтөнг эмчилгээг бүрэн дуусгахад дэмжлэг үзүүлэх болон өвчний эхний үед цаашид хүндрэхээс сэргийлэх

## Дэлгэрэнгүй

- Шинээр сүрьеэгээр өвчилсөн өвчтөнд 2 буюу түүнээс дээш долоо хоно гийн турш хяналтат эмчилгээ хийх
- Өвчтөн бүрийн нөхцөл байдал, боломжийг харгалзан үзэж эмчилгээ хийх

## Өвчтөнд туслах менежментийн арга замууд

Эмчилгээний хянагч ажилтан нь өвчтөний эмчилгээ, эмчилгээний явц, цагийн хувиар ийг хянаж зохицуулах, өвчтөнтэй утсаар х олбогдох, сануулах, аливаа эмийн гаж нөл өө илэрч байгаа эсэхийг хянахад тусална.

### Гар утсаар өвчтөнтэй шууд харилцах

Өвчтөн гар утсандаа (TB Zero) нэртэй апп ликейшн суулгаснаар өөрийн эмчилгээ, э м уух явцийг хянагч эмнэлэгийн ажилтан руу видео хэлбэрээр илгээн харилцана.

### Өөрийн биеэр ирж уулзах

Өвчтөн эмнэлэг болон эрүүл мэндийн төв үүд дээр өөрийн биеэр очиж эмчилгээ, эм ийн гаж нөлөөний талаар ярилцаж зөвлөг өө авах боломжтой.

## Эмчилгээний шууд хяналт

- Эм олгох
- Эмээс шалтгаалсан сөрөг өөрчлөлт, эмчилгээг түр зогсоох



환자수첩-몽골.indd 11 2016. 11. 15. 오후 5:01

# “Сүрьеэ өвчнийг анагаах ямар төрлийн эм, тарилга байдаг вэ[3]?”

- Сүрьеэ өвчтөний эмчилгээг “I түвшний” буюу хамгийн үр дүнтэй, эм ийн гаж нөлөө багатай болон "II түвшний" буюу хүндэрсэн, шаардла гатай тохиолдолд зөвлөдөг эмийн гаж нөлөө ихтэй эмчилгээ гэж анг илдаг
- Мөн үр дүн, эмийн үйлчлэх үйлдлээс нь хамааран сүрьеэ өвчний эс рэг эмийг 5 бүлэгт хуваагддаг.

## Сүрьеэгийн эсрэг эмчилгээ - бүлэг 1

- I түвшний эм, эмийн бэлдмэл буюу сүрьеэгийн эсрэг үйлчилгээ сайт ай, элдэв гаж нөлөө багатай үндсэн эмүүд ордог.

Изониазид Рифампин Этамбутол Пиразинамид Рифабутин

## Сүрьеэгийн эсрэг эмчилгээ - бүлэг 2, 3, 4, 5 (II түвшний эмчилгээ)

Өвчтөн сүрьеэгийн эмэнд дасал болсон, эмийн гаж нөлөө их тохиолд олд, мөн I түвшний эмчилгээ үр дүнгүй үед хэрэглэнэ.

◉ Сүрьеэгийн эсрэг эмчилгээ - бүлэг 2 (Тарилга)



Канамицин Амикацин Капреомици Стрептомицин

◉ Сүрьеэгийн эсрэг эмчилгээ - бүлэг 3 (Хинолины бүлгийн эм)

Левофлоксацин Моксифлоксацин Офлаксацин

◉ Сүрьеэгийн эсрэг эмчилгээ - бүлэг 4 (II түвшний сүрьеэгийн эсрэг эм)

Профионами Циклосерин Парааминосалицилийн хүчил (ПАС)

◉ Сүрьеэгийн эсрэг эмчилгээ - бүлэг 5 (Заавал эмчийн хяналтан дор)

Бедаквилин Клофазимин Линезолид Амоксицилин Кларитромицин Имипемем

* Эмийн хэлбэр дүрс үйлдвэрлэгчээс хамааран өөрчлөгдөж болно.



환자수첩-몽골.indd 12 2016. 11. 15. 오후 5:01

# “ I түвшний эмчилгээний үед ямар газ нөлөө илэрч болох вэ[2]? ”

Сүрьеэгийн эмийн газ нөлөөнөөс үүсэх хамгийн их тохиолддог сөрөг нөлөө бол элэгний хордолт юм. Үүний үр дүнд үүсэх шинж тэмдэг, ил рэх байдал нь өвчтөн бүрт өөр байж болно.

◉ Элэгний хордолт (Изониазид Рифампин Пиразинамид)

толгой эргэх | хавагнах | арьс шарлах

Үүсэх шинж тэмдэг, илрэх байдал нь өвчтөн бүрийн эмчилгээнээс шал тгаалж өөр өөр байж болно.

Арьс загатнах, гар х өл бадайрах, эрвэг нэх | Үе мөч өвдөх | Шээс, нулимс улаан болох | хараа муудах

Изониазид | Рифампицин | Пиразинамид | Этамбутол

√ Сүрьеэгийн эмчилгээний явцад үүсч болох эмийн газ нөлөөний тухай ойлголттой байх нь чухал.

√ Газ нөлөөнөөс шалтгаалаад эмчилгээгээ зогсоож болохгүй.

√ Илэрч буй эмийн газ нөлөөг эмчтэйгээ зөвлөж шийдвэрлэх нь чухал.



환자수첩-몽골.indd 13 2016. 11. 15. 오후 5:01

## “Сүрьеэгээр өвчилсөн тохиолдолд анхаарах зүйлс юу вэ[2] ?”

### Маск зүүх

Бусад хүмүүст халдварлахаас сэргийлж маск зүүнэ.

### Архи тамхинаас татгалзах

нь сүрьеэгийн эсрэг эмчилгээг амжилттай болоход нөлөөлнө.

### Амин дэм, тэжээллэг сайтай хоол хүнс хэрэг глэснээр

биеийн дархлаа сайжирна.

√ Сүрьеэтэй өвчтөн үндсэн дэглэмүүдийг сахих нь хүмүүст сүрьеэ өвчнийг халдаахаас сэргийлж буй хэрэг юм.



환자수첩-몽골.indd 14 2016. 11. 15. 오후 5:01

# “Нуугдмал сүрьеэ өвчин гэж юу вэ? Хэрхэн эмчлэгддэг вэ[2]?”

## Нуугдмал сүрьеэ өвчин гэж юу вэ?

- ○ Сүрьеэгийн нянгийн халдвар
- X Шинж тэмдэгүүд, халдвар

→ Биеийн дархлаа сулрах үед сүрьеэгийн нян идэвхжилт

- Нуугдмал сүрьеэгийн нян өвчтөний биед нуугдаж байдаг.
- Нуугдмал сүрьеэгийн нян тэсэн өвчтөн бусдад халдаадаггүй ба өөрт нь аливаа шинж тэмдэг илэрдэггүй.
- Түрхэцийн шинжилгээний хариу болон цээжний рентген зураг хэвийн байна.

## Нуугдмал сүрьеэ өвчний эмчилгээ

- Хэдэн сарын турш 1~2 төрлийн эмчилгээ хийгдэж байж идэвхтэй сүрьеэ өвчнөөс урьдчилан хамгаална.






환자수첩-몽골.indd 15 2016. 11. 15. 오후 5:01

## “Сүрьеэгийн халдвартай өвчтөний гэр бүлд зориулсан “Нуугдмал сүрьеэг илрүүлэх шинжилгээ - төсөл” гэж юу вэ[1]?”

### Ач холбогдол

- Сүрьеэгийн халдвартай өвчтөний гэр бүл, найз нөхөд, хамтран ажи ллагсад сүрьеэгийн халдвар авч болзошгүй.
- Биеийн дархлаа муудахад нуугдмал сүрьеэгийн нян идэвхжих боломжтой.

### Ерөнхий

- Уг төсөл нь сүрьеэгийн халдвартай өвчтнүүдийн гэр бүл,болон ойр хари лцаж байсан хүмүүсийг нуугдмал сүрьеэгийн нянтай эсэхийг тогтоох ши нжилгээ өгөхөд санхүүгийн дэмжлэг үзүүлж тусалдаг.

### Дэлгэрэнгүй

- Эрүүл мэндийн төв, эмнэлэгүүдэд сүрьеэ өвчний халдвар авсан нь оно шлогдсон өвчтөнүүдээс “Ойр харилцаж байсан хүмүүсийн нэрсийн жаг саалт” анкетийг бөглүүлнэ.
- Сүрьеэгийн өвчтөнтэй 1 сарын дотор ойр хавьталд байсан хүмүүс эрүүл мэнд төвүүд болон бусад газруудад үнэгүй шинжилгээ хийлгэх боломжтой.
- Сүрьеэгийн шинжилгээ: цээжний рентген, цэрний түрхэцийн, нянгийн
- Нуугдмал сүрьеэгийн нянг илрүүлэх шинжилгээ: тюберкюлин арьсны шинжилгээ

환자수첩-몽골.indd 16 2016. 11. 15. 오후 5:01

III хэсэг.

# Эмэнд дасал сүрьеэ



## “Эмэнд дасалтай сүрьеэ хэрхэн үүсдэг вэ[1]?”

- Эмэнд дасалтай сүрьеэ нь сүрьеэгийн 1-с дээш эмд тэсвэртэй байдаг.
- Ихэнх тохиолдолд өвчтөн эмийг зааврын дагуу уугаагүйгээс үүддэг. Үүнд:
  - Өвчтөн эмчилгээний заавар дүрмийг чанд мөрдөхгүй, эмчилгээгээ тасл асан бол
  - Эмчилгээний жор буруу эсвэл буруу эмчилгээ хийлгэвэл
  - Өвчтөн эмэнд дасал сүрьеэтэй өвчтнөөс нянгийн халдвар авсан бол
- Эмэнд дасал сүрьеэ болон хүндэрсэн тохиолдолд сүрьеэгийн эсрэг эм үйлчлэхээ болино гэсэн үг.

환자수첩-몽골.indd 18 2016. 11. 15. 오후 5:02

## “Эмэнд дасал сүрьеэгийн олон янз байдаг уу[1]?”

| | |
|---|---|
| Олон Эмэнд Дасал Сүрьеэ (ОЭДС) | Энэ нь изионамид, рифампицины хослолд тэсвэртэй тохиолдлыг хэлнэ. Энэ тохиолдолд II түвшний эмчилгээтэй хавсарсан ч эмчилгээний үр дүн 50% магадлалтай байдаг. |
| Хэт Олон Эмэнд Дасал Сүрьеэ (ХОЭДС) | Изониазид, рифампицины хослолоос гадна аль нэг II түвшний бүлэг эмэнд дасал буюу тарилга, хинолины бүлгийн эмд тэсвэртэй байхыг хэлнэ. |

√ ОЭДС нь изионамид, рифампицин эмд тэсвэртэй тохиолдлыг хэлнэ.

√ ХОЭДС нь тарилга, хинолины бүлгийн эм, эмчилгээнд тэсвэртэй байна.



환자수첩-몽골.indd 19 2016. 11. 15. 오후 5:02

## “Олон эмэнд дасал сүрьеэг хэрхэн эмчилдэг вэ[3]?”

Изионамид, рифампицин зэрэг эмд нэгэнт тэсвэртэй болсон нянг ихэ вчлэн II түвшний эмчилгээ хийгддэг.

### ОЭДС-г эмчимлэх эрчимт эмчилгээ

- Пиразинамид + 4 төрлийн II түвшний эмнүүд (тарилгыг оролцуулан)
- 8 сарын турш

환자수첩-몽골.indd 20 2016. 11. 15. 오후 5:02

## “2-р эгнээний эмнүүдээс үүсэх үндсэн газ нөлөө нүүд юу вэ[3-5]?”

| | Сүрьеэгийн Эсрэг Эмчилгээнүүд | Хэлбэр, дүрс | Газ нөлөөнүүд |
|---|---|---|---|
| Бүлэг 2 | Тарилгууд | | Чихний үрэвсэл,бөөрний үрэвсэл, амны дотор хэсэг хорсох |
| Бүлэг 3 | Левофлоксацин | | Гэдэс дүүрэх,Толгой өвдөх, толгой эргэх,үе мөч янгинах |
| | Моксифлок сацин | | |
| | Офлоксацин | | |
| Бүлэг 4 | Циклосерин | | Сэтгэл санаагаар унах,сэтгэл мэдрэлийн өвчлөл тусах |
| | Протионамид | | Гэдэс дүүрэх,элэгний |
| | ПАС | | Хоолнд дургүй болох,дотор муухайрах,бөөлжих,гэдэс өвдөх,элэг хордох |
| Бүлэг 5 | Линезолид | | Цусны эс багасалх гар хөл бадайрах, сулбайх |
| | Бедаквилин | | Зү рхний хэм алдах,амьсгал давчдах,элэг хордох |
| | Деламанид | | Зүрхний хэм алдагдах,дотор муухайрах,бөөлжих,нойргүй |

* Эм үйлдвэрлэгчээс шалтгаалж эмийн зураг өөрчлөлттэй байж



환자수첩-몽골.indd 21 2016. 11. 15. 오후 5:02

## “Сүрьеэгийн эсрэг шинэ төрлийн эм, тарилга байгаа юу[4-7]?”

### Бэдаквилин [4,6]

Бэдаквилин эм нь микробактерийг дарангуйлах эм нь А ТП (аденозин 5-трипосфит) хэмээх сүрьеэгийн эрчим х үч үйлдвэрлэгч ферментийн задралын хурдыг сааруула х ач холбогдолтой. Сүүлийн үеийн эмнэлгийн туршилта ар уг эмийг хэрэглэсэн ОЭДС-тэй өвчтөнгүүд сүрьеэгий н нянгийн үржил удааширч байгаа нь батлагдсан.
Бэдаквилин эмийг өдөрт 400мг-аар хоёр 7 хоног, дараа нь 200 мг-аар 7 хоногт 3 удаагийн давтамжтайгаар 22 д ахь 7 хоног хүртэл ууна. Дээд тал нь 6 сар уух бөгөөд х оолтой хамт ууж хэрэглэх нь илүү үр дүнтэй байна.

### Деламанид [5,7]

Деламинид сүрьеэгийн эсийн нэг хэсэг болох миколик э сийн задралыг сааруулах үйлчилгээтэй. Сүүлийн үеийн эмнэлгийн туршилтаар уг эмийг хэрэглэсэн ОЭДС-тэй ө втөнгүүд эмчилгээний 2 сарын дараах цэрний түрхэций н шинжилгээгээр илааршиж хурд ердийн сүрьеэгийн эм чилгээнээс илүү  байгаа нь батлагджээ.
Насанд хүрэгчид уг эмийг өдөрт 100мг-аар өдөрт хоёр удаа 24 долоо хоног хүртэл хоолны хамт ууна.

환자수첩-몽골.indd 22 2016. 11. 15. 오후 5:02

# “Сүрьеэ өвчин эдгэрсний дараа дахин өвчлөх магадлалтай юу[1]?”

Бүрэн эдгэсэн хүмүүсийн 3% орчим нь дахин өвчлөх магадлалтай ба йдаг. Биеийн дархлаа суларснаар сүрьеэгийн нян дахин идэвхижих т охиолдол бий.

## Дахин өвчлөх эрсдлийн хүчин зүйлс

- Биеийн онцлог
- хүрээлэн буй орчин
- өдөр тутмын зуршил
- стресс
- Биеийн дархлаа муутгах суурь өвчингүүд (чихрийн шижин, элэгний өвчин, ДОХ)
- Биеийн дархлаа муудахад нөлөөлөх эмчилгээ (гемодиализ, адренокордикол стериод, дархлаа даран гуйлагч, хорт хавдрын эсрэг эмчилгээ)
- өндөр нас (Настай хүмүүс ихэвчлэн дахин тусах магадлалтай)

Суурь өвчтэй өвчтөнгүүд эмчийн хяналтад эрчимт эмчилгээ хийлгэх хэрэгтэй. Мөн амин дэмээр баялаг хоол хүнс хэрэглэн, сэтгэл санаан ы хямралаас өөрийгөө хамгаалж сүрьеэгээр дахин өвчлөхөөс сэргий лэх хэрэгтэй.

환자수첩-몽골.indd 23 2016. 11. 15. 오후 5:02

Lung tree care

Хэвлэлийн Газарын тухай Мэдээлэл

1. Korean National Tuberculosis Association 57 Baumoero 6(yuk)-gil, Seocho-gu, Seoul, 137-900, Korea Tel.+82-2-2633-9461 2. Janssenkorea 25F, LS Yongsan Tower, Hangangro 2-Ga, Yongsan-Gu, Seoul 140-702, Korea Tel.+82-2-2094-4500

Хавсралт

1. CDC Korea, TB Zero. Available at http://tbzero.cdc.go.kr/tbzero/main.do Accessed November 3,2015. 2. Korean National Tuberculosis Association. Tuberculosis Guidebook Brochure. Korean National Tuberculosis Association>Reference Library>Promotional Education Data. Available at http://www.knta.or.kr/reference/promotion/promotionView.asp?idx=73&search_type=&search_text=&page=2 Accessed November 3,2015. 3. Tuberculosis Guideline Revision Committee. Tuberculosis Guideline 2014. The Korean Academy of Tuberculosis and Respiratory Disease, CDC Korea. 4. Sirturo® PI 5. Deltyba® PI 6. Diacon AH, Pym A et al., Multidrug-resistant tuberculosis and culture conversion with bedaquiline. N Engl J Med. 2014 Aug 21;371(8):723-32 7. Gler MT, Skripconoka V et al., Delamanid for multidrug-resistant pulmonary tuberculosis. N Engl J Med. 2012 Jun 7;366(23):2151-60